

**ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН
ШУДАРГА ӨРСӨЛДӨХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ
НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ**

**ӨРГӨН
НЭВТРҮҮЛГИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР**

2024

АГУУЛГА

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөхцөл байдалд хийсэн үнэлгээ, дүгнэлт	2
I. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	3
Нэг. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр	3
Хоёр. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хийсэн үнэлэлт, дүгнэлт	4
Гурав. Зохицуулах хорооноос хийж гүйцэтгэсэн хяналт, шалгалтын талаар	5
Дөрөв. Зохицуулах хорооноос хийж байгаа хяналт, мониторингийн талаар	7
Тав. Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил	7
II. ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН, СУНГАСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН, СЭРГЭЭСЭН, ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТОО, МЭДЭЭ	8
Нэг. Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо тогтоосон байдал, сонгон шалгаруулалтын дүн	9
Хоёр. Төлбөртэй телевизийн төрөлд тусгай зөвшөөрөл олгох хүсэлт шийдвэрлэсэн байдал	10
Гурав: Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн арга хэмжээний талаар	10
Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байдал	10
Тав. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байдал	11
Зургаа. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал	12
III. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙЛГАХ ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ	13
IV. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ, ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ	13
Нэг. Монгол Улсын хүн ам, өрхийн тоо, нягтралын байдал	13
Хоёр. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо	13
Гурав. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдал	14
Дөрөв. Эрэлт, хэрэгцээ	17
V. ХОРООНООС 2024 ОНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОО ТОГТООХ ЭСЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ХАРГАЛЗАН ҮЗСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ШИЙДВЭР	18
Нэг. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлтүүд	18
Хоёр: Тус Хорооноос 2024 онд сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх тухай	20

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөхцөл байдалд хийсэн үнэлгээ, дүгнэлт

2024 он

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (ӨНТХ)-иар олгогдсон бүрэн эрх, чиг үүрэг, өргөн нэвтрүүлгийн салбарт төрөөс баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалт хийж, зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг хэрэгжүүлж ажилладаг.

ХХЗХ нь ӨНТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т заасан эрх, үүргийн дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, жил бүр үнэлэлт, дүгнэлт гаргаж ажиллах бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

ӨНТХ-иар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчилсан. Иймээс өргөн нэвтрүүлгийн бодлого, зохицуулалтын болон өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаанд зайлшгүй баримтлах зарчмуудыг хуулийн 5 дугаар зүйлээр заасан ба 5.1.9-д "... зах зээлийн өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлж, өргөн нэвтрүүлгийн салбарын хөгжлийг дэмжин хөгжүүлэх" зарчмыг баримтлахаар заасан билээ.

ХХЗХ нь ӨНТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1.10-т заасныг үндэслэн хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж, дүрэм журам, нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангуулах замаар өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээтэй холбоотой онцлог зохицуулалтыг хэрэгжүүлж, өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах, шударга өрсөлдөх нөхцөлийг бий болгох, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор ӨНТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасны дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн талаарх мэдээллийг ил тод байлгаж, 19.5-д зааснаар жил бүр олон нийтэд мэдээлж байна. ХХЗХ нь дээр чиг үүрэг, зорилгын дагуу хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотой үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг тогтмол авч ажиллаж байгаа бөгөөд зах зээл, хүн ам, эрэлт хэрэгцээ, эзэмшил, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгаанд үндэслэн өрсөлдөх нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, тусгай зөвшөөрлийн тоо тогтоох, олгох эсэх шийдвэрийг судалгаа, үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн гаргаж байна.

Тус хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт гаргахад дараах үндсэн чиглэлийг авч үзсэн бөгөөд эдгээр чиглэлийн хүрээнд хийсэн судалгаа, мэдээлэлд үндэслэн үнэлэлт, дүгнэлт гаргасан болно. Үүнд:

- I. Өргөн нэвтрүүлгийн хууль эрх зүйн орчин, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хийсэн үнэлэлт, дүгнэлт, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

- II. Тайлант хугацаанд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх хуульд заасан тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тоо, мэдээ;
- III. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эзэмшлийн талаарх мэдээллийг ил тод байлгах зохицуулалт, хэрэгжилтийн нөхцөл байдал, үнэлэлт, дүгнэлт;
- IV. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээл, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаа, үнэлэлт, дүгнэлт;
- V. Тус хорооноос 2024 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлт, шийдвэр.

Дээрх чиглэлээр тус Хорооноос хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, мэдээлэл, судалгаа, үнэлгээ дүгнэлтийг дэлгэрэнгүй авч үзье.

I. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Нэг. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр

ХХЗХ нь “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-д 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан. Журамд телевизээр нэвтрүүлэх эд мөнгөний хонжворт сугалааны нэвтрүүлгийн зохицуулалт, эм, эмнэлгийн хэрэгслийн зар сурталчилгаанд тавих шаардлага, хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэмд нийцүүлэн хүүхдийн сэтгэхүй, бие махбодод сөргөөр нөлөөлөх хүнсний бүтээгдэхүүнийг хүүхдийн нэвтрүүлгийн үеэр сурталчлахгүй байхтай холбоотой хязгаарлалт, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хоорондын уялдааг хангахтай холбогдсон зохицуулалт зэргийг нэмэлт, өөрчлөлтөөр баримт бичигт тусгасан. Журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хорооны 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн баталж (Хорооны 2023 оны 51 дүгээр тогтоол), Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг хийлгэн бүртгүүлсэн.

Тус Хорооноос “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”, “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” зэрэг баримт бичгүүдэд Хорооны даргын 2023 оны А/182 тоот тушаалын хавсралтаар баталсан “Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж”-ийн дагуу 2023 оны 4 дүгээр улиралд үнэлгээ хийж, хэрэгжилтийн байдлыг гарган тайланг Даргын зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцсэн.

Баримт бичгүүдэд хийсэн дүн шинжилгээгээр баримт бичгийн зүйл, заалт тус бүрийн хэрэгжилтийг Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлөөр хүлээсэн үүрэг, хөтөлбөрийн биелэлт, зар сурталчилгааны зохицуулалт, нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн байдлыг гаргаж, үнэлгээ хийсэн.

“Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын хэрэгжилтэд хийсэн үнэлгээнд Улаанбаатар хот болон орон нутагт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа телевизийн үйлчилгээ эрхлэгчийн хөтөлбөрөө дахин дамжуулж байгаа хамрах хүрээний асуудлыг мөн авч үзсэн.

Орон нутгийн телевизүүдийн тухайд хөтөлбөрөө олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжуулан зөвхөн тусгай зөвшөөрөлд заасан буюу өөрийн аймагт хүргэх боломжтой харин бусад аймаг, сумдад дахин дамжуулах хязгаарлагдмал зохицуулалт үйлчилж байсан.

Орон нутгийн ард иргэдэд тухайн аймаг, бүс нутагт болж байгаа үйл явдлын мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авах хэрэгцээ шаардлагын үүднээс аймаг, орон нутагт радио, телевизийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байдаг.

Тус Хорооны зүгээс 2023 онд телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг 2 удаагийн сонгон шалгаруулалтаар 8 аймагт зарласан боловч ердөө 2 аймагт хүсэлт ирж тусгай зөвшөөрөл олгогдсон бөгөөд бусад 6 аймагт хүсэлт ирээгүй, тухайн орон нутгийнхаа мэдээ, мэдээллийг телевизийн үйлчилгээгээр дамжуулан авах боломжгүй хэвээр байна.

Түүнчлэн аймаг, орон нутгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн зүгээс “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 2.6 дахь заалтаар аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглосон заалтыг эргэн харж тухайн бүс нутаг, зэргэлдээ аймагтаа үйлчилгээг хүргэх боломжийг олгох хүсэлт тавьдаг.

Иймд тус Хорооны зүгээс “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу олон нийтэд нээлттэй байршуулж, холбогдох газруудаас санал авч, саналыг тусган Хорооны 02 дугаар сарын 22-ны өдрийн 33 дугаар тогтоолоор нөхцөл, шаардлагад оруулах нэмэлт, өөрчлөлтийг баталсан. “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 5060 дугаарт холбогдох хөдөлгөөнийг хийлгэснээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хийсэн үнэлэлт, дүгнэлт

Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хамаарах “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”, “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” зэрэг зохицуулалтын баримт бичгүүдэд холбогдох удирдамжийн дагуу хийсэн үнэлэлт, дүгнэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Баримт бичгүүдэд үнэлгээг хийхдээ Хорооны даргын 2022 оны А/89 тоот болон 2022 оны А/254 тоот тушаал, удирдамжийн хүрээнд тус тус телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дүн, хөтөлбөрийн мониторингийн 2023 оны эхний хагас жилийн тайлан, үзэгч, олон нийтээс 2022, 2023 онуудад ирсэн өргөдөл, гомдол зэрэг мэдээлэлд үндэслэн хийж гүйцэтгэсэн.

Радиоогийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулсан “Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Радиоогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”,

“Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” баримт бичгүүдэд радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд Хорооны даргын 2023 оны А/106 тоот тушаал, удирдамжийн хүрээнд хийсэн хяналт, шалгалтын дүн, хөтөлбөрийн мониторингийн тайлан, сонсогчдоос 2022, 2023 онуудад ирсэн өргөдөл, гомдол зэрэгт үндэслэн хийж гүйцэтгэн, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.

2024 онд олон суваг дамжуулах үйлчилгээний болон радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээний тусгай зөвшөөрлийн баримт бичгүүдэд “Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж”-ийн дагуу үнэлгээ, дүгнэлт өгөхөөр төлөвлөн ажиллаж байна.

Гурав. Зохицуулах хорооноос хийж гүйцэтгэсэн хяналт, шалгалтын талаар

ХХЗХ нь Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг хийж хуульд заасан холбогдох арга хэмжээг авч, зөвлөгөө мэдээлэл өгч ажилладаг.

Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгчдэд Хорооны даргын 2023 оны А/46 тоот тушаал, удирдамжийн дагуу хяналт, шалгалт хийж радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 2 үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт, шалгалт хийж, шалгалтын хүрээнд үйлчилгээ эрхлэгчийн хүсэлтийг үндэслэн 1 үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээ эрхлэх, радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд хорооны даргын 2022 оны А/318 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд хийсэн төлөвлөгөөт хяналт, шалгалтын тайланг 2023 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн Даргын зөвлөлийн хуралд, 1 дүгээр сарын 31-ний өдрийн Хорооны хуралд танилцуулж, дүнг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Шалгалтын дүнгийн дагуу 3 газарт хугацаатай үүрэг даалгавар (Монголсат нэтворкс ХХК, Оримедиа ХХК, Талст эрчим ХХК), 1 газарт албан шаардлага (Оптимум нэтворк ХХК), 8 газарт шалгалтын дүн зөвлөмж (ДДЭШ ТВ ХХК, Мобинэт ХХК, МЦХ ХК, Сансар дижитал ХХК, Скаймедиа ХХК, Шинэ сансар ХХК, Эн би си ХХК, Юнивишн ХХК) хүргүүлсэн. Үйл ажиллагаа эхлүүлээгүй 1 газарт (Хийморь кабелийн телевиз ХХК) үйл ажиллагаа эхлүүлэх тухай мэдэгдэл хүргүүлсэн.

Дээрх Шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгах гүйцэтгэлийн шалгалтыг хорооны даргын 2023 оны А/329 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу 4 ОСДҮЭ (Оримедиа ХХК, Оптимум нэтворк ХХК, Хийморь кабелийн телевиз ХХК, Талст эрчим ХХК)-ийн үйл ажиллагаанд хийж гүйцэтгэн, шалгалтын тайлан, авах арга хэмжээний саналыг 2023 оны 12 дугаар сарын Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Шалгалтаар үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй биелэлттэй байсан тул эдгээр 4 ОСДҮЭ-д тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх сонсох ажиллагаа 12 дугаар сарын 14-ний өдрийн албан бичгээр хийсэн. Сонсох ажиллагаа хийсэн хугацаанд үйлчилгээ эрхлэгчид хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх тайлан мэдээ, нотлох баримтыг ирүүлсэн тул үүрэг даалгаврыг биелүүлсэн гэж үзсэн.

Бүсийн төлөвлөгөөт хяналт, шалгалтын хүрээнд тус Хорооны даргын 2023 оны А/47 тоот тушаал, удирдамжаар Төв, Дундговь, Өмнөговь аймгуудад, 2023 оны А/111 тоот тушаал, удирдамжаар Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад, 2023 оны А/149 тоот тушаал,

удирдамжийн дагуу Улаанбаатар хотын Налайх дүүрэг, Говьсүмбэр, Дорноговь аймгуудын нийт 23 өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар 11 үйлчилгээ эрхлэгчид хугацаатай үүрэг даалгавар, 12 үйлчилгээ эрхлэгчид заавар, зөвлөмж хүргүүлсэн. Өвөрхангай аймагт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 1 радио үйл ажиллагаагаа зогсоож, шалгалтад хамрагдаагүй болно. Заасан хугацаанд зөрчил дутагдлаа арилгасан тухай мэдээ, тайлан ирүүлсэн тул үүрэг даалгаврын биелэлтийн хангасан гэж үзсэн. Үйл ажиллагаагаа зогсоосон байсан Өвөрхангай аймгийн радио үйл ажиллагаа хэвийн явуулж эхэлсэн. Шалгалтын үеэр холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар бүх үйлчилгээ эрхлэгчийг хамруулан сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Улаанбаатар хотын телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд хяналт, шалгалт хийх ажлын хүрээнд тус Хорооны даргын 2023 оны А/254 тоот тушаал, удирдамжийн хүрээнд хийсэн шалгалтын дүнгээр хугацаатай үүрэг даалгавар өгөгдсөн, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон өмнөх шалгалтад хамрагдаагүй телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд Хорооны даргын 2023 оны А/52 тоот тушаал, удирдамжийн дагуу гүйцэтгэлийн болон төлөвлөгөөт хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Уг шалгалтын хүрээнд өмнөх шалгалтын дүнгээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн байсан 6 телевизийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн шалгалт хийж шалгалтын дүнгээр 5 телевизийн тусгай зөвшөөрлийг сэргээж, 1 телевизийн (Эм Ви Эс ХХК-ийн MonPlus) тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох сонсгол хийсэн. Сонсголын хугацаанд зөрчил дутагдлаа арилгасан тул тусгай зөвшөөрлийг сэргээсэн.

Мөн А/52 тоот тушаал, удирдамжийн хүрээнд хийсэн төлөвлөгөөт хяналт, шалгалтад 9 телевизийн үйлчилгээ эрхлэгч хамрагдахаас 8 үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, тайланг Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, 2 үйлчилгээ эрхлэгчид хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Үүрэг даалгаврын биелэлтийг 2 дугаар улиралд танилцуулахаар бэлтгэж байна. Үйл ажиллагаа явуулаагүй 1 телевизийн хүсэлтийг хүлээн авч шалгалтыг хойшлуулсан.

Улаанбаатар хотод арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлын хүрээнд тус Хорооны даргын 2023 оны А/106 тоот тушаал, удирдамжаар 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 05 дугаар сарын 19-ний өдрүүдэд 31 радиогийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт, шалгалтын тайлан, авах арга хэмжээний саналыг 06 дугаар сарын 15-ны өдрийн Даргын зөвлөлийн хурал, 06 дугаар сарын 30-ны өдрийн Хорооны хуралд тус тус танилцуулж шийдвэрлүүлсэн. Шалгалтын дүнгээр 16 радиогийн үйлчилгээ эрхлэгчид зөвлөмж хүргүүлж, 6 үйлчилгээ эрхлэгчид хугацаатай үүрэг даалгавар өгсөн бол 9 радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх сонсох ажиллагаа явуулснаас 3 үйлчилгээ эрхлэгчийн (Шүхэр ТББ-ийн Хамаг Монгол FM-95.1, Улаанбаатар телевиз ХХК-ийн VIP радио FM 90.5 И Зэт Эф Эм ХХК-ийн Эх дэлхий FM-107) тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн. Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгасан тул эдгээр 3 радиогийн тусгай зөвшөөрлийг сэргээсэн. Шалгалтын тайлан, цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээг 06 дугаар сарын 21-ний өдөр Радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн дунд зохион байгуулсан семинар, хэлэлцүүлгийн үеэр танилцуулсан.

Дөрөв. Зохицуулах хорооноос хийж байгаа хяналт, мониторингийн талаар

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс үйлчилгээний тасралтгүй ажиллагааны тайлан (ТАТ) тогтмол хүлээн авч, үйлчилгээний хэвийн тасралтгүй ажиллагааг хангуулах чиглэлээр телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн эфирийн ТАТ тайланг тус хорооноос хийдэг байнгын хяналт, мониторингийн хүрээнд болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид, телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс гэсэн 3 талаас хүлээн авч нэгтгэн, анализ хийж байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. (<https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=254>). Үйлчилгээ нь тасарсан үйлчилгээ эрхлэгчдээс эфир тасарсан шалтгааныг тодруулж, хариу тайлбар авч, анхааруулга хүргүүлэн ажиллаж байна.

ХХЗХ нь ӨНТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1.8-д заасан эрх, чиг үүргийн хүрээнд “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”, “Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Радиоогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын хэрэгжилтэд байнгын хяналт, мониторинг хийж байна.

- Телевизийн хөтөлбөрт хийдэг байнгын хяналт, мониторингийн хүрээнд:
 - Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүд (үүнд: Монголын үндэсний олон нийтийн 5 телевиз, өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, арилжааны 54 телевиз) мониторингид тогтмол хамрагдаж байна.
 - Орон нутагт тусгай зөвшөөрөлтэй нийт 45 телевизийн хөтөлбөрт түүврийн аргаар буюу сард 15 телевизийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийж байна.
- Радиоогийн хөтөлбөрт хийдэг байнгын хяналт, мониторингийн хүрээнд:
 - Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй радиоогийн (Монголын үндэсний олон нийтийн 4 радио, арилжааны 33 радио) хөтөлбөрт түүврийн аргаар буюу сар бүр 10 радиоогийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийж байна.

ХХЗХ нь радио, телевизүүдийн хөтөлбөрт хийсэн хяналт, мониторингийн тайланг үйлчилгээ эрхлэгчдэд тогтмол хүргүүлэх, холбогдох арга хэмжээ авах, хяналт, мониторингийн тайлан, мэдээг олон нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна. Телевизийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн тайлан, мэдээллийн дэлгэрэнгүйг <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=27> хуудаснаас, радиоогийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүн, мэдээллийн дэлгэрэнгүйг <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=251> хуудаснаас сар, улирлаар нэгтгэсэн байдлаар дэлгэрэнгүй үзэх боломжтой.

Түүнчлэн радио, телевизүүдийн хөтөлбөрийн мониторингийн бүтэн жилийн тайлан, мэдээг аналитик дүгнэлттэйгээр бэлтгэн товхимол болгон хэвлүүлэн үйлчилгээ эрхлэгчдэд болон холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэн, мэдээллээр ханган ажиллаж байна.

Тав. Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил

Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих Орон тооны бус зөвлөлийн хурлыг холбогдох журмын дагуу тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд иргэдээс телевизээр хүүхдэд зохисгүй агуулга, хараалын үг, хэллэг зэргийг гаргаж байгаа талаарх 7 гомдол ирснийг хүлээн авч, гомдлын дагуу тухайн радио,

телевизийн үйлчилгээ эрхлэгчидтэй холбогдож хяналт тавьж ажиллах чиглэл, зөвлөмж өгөх, Орон тооны бус зөвлөлд танилцуулж, хэлэлцүүлэн, зөвлөмж гарган үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлж ажиллалаа. Энэ талаар иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд болон гомдол гаргасан тухайн иргэдэд хариу тайлбар, мэдээлэл өгөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Орон тооны бус зөвлөлийн ээлжит 4 удаагийн хурлыг зохион байгуулсан. Хурлаар тус Хорооноос хийдэг радио, телевизийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн тайлангаас 18+ кино, нэвтрүүлэг нэвтрүүлсэн зөрчлийн талаар, мөн иргэдээс ирүүлсэн гомдлын талаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан, үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлсэн. Түүнчлэн 2024 онд хийгдэх шторкийн агуулга, Кино урлагийн зөвлөл, өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр НҮБ-ийн дэмжлэгтэй хийж, хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны санал бэлтгэн танилцуулж, гишүүдээс санал авч ажилласан. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн гомдол, зөвлөлийн ажилласан тайлан, мэдээг бэлтгэн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлсэн. (<https://www.crc.gov.mn/articles/mny>).

Үзэгч, олон нийтэд мэдээлэл хүргүүлэх зорилгоор хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах тухай болон орон тооны бус зөвлөлд хэрхэн гомдол гаргах агуулга бүхий телевизийн 2 шторкийг шинээр бэлтгэн, өмнөх онд хийгдсэн 2 шторкийн хамт телевизүүдээр нэвтрүүлэн ажиллаж байна.

Тус Хорооны зүгээс Нийгмийн эрүүл мэндийн төвөөс зохион байгуулсан хэлэлцүүлэгт Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн төвөөс хамтран зохион байгуулсан "Балчир насны хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаа" сэдэвт хэлэлцүүлгээр "Телевизээр нэвтрүүлж буй хүүхдэд чиглэсэн хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаа" судалгааны мэдээлэл зэргийг тус тус бэлтгэж танилцуулсан.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн дунд 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан сургалтад "Телевизээр нэвтрүүлж буй хүүхдэд чиглэсэн хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаа"-ны мониторингийн дүнгээр бэлтгэсэн судалгааг танилцуулсан.

Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгөх саналыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.

II. ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН, СУНГАСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН, СЭРГЭЭСЭН, ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТОО, МЭДЭЭ

ХХЗХ-ноос 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох, ӨНТХ-ийн 6.1.6-д заасан төрөлд тусгай зөвшөөрөл олгох, мөн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, дуусгавар болох үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу дараах байдлаар хэрэгжүүлж ажилласан.

Нэг. Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо тогтоосон байдал, сонгон шалгаруулалтын дүн

Зохицуулах хорооны 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 35 тоот тогтоолоор 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн тоо, үйлчилгээ эрхлэх хүрээ, нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлах хугацааг баталсан. Тус тогтоолоор орон нутагт үйлчилгээ эрхлэх арилжааны радиогийн 10, өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизийн 8, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх 1, түүнчлэн Монгол Улсад хамрах хүрээтэй олон суваг дамжуулах үйлчилгээ (ОТТ)-ний 1 гэсэн нийт 20 тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр нээлттэй зарласан бөгөөд хүсэлт ирээгүй төрөл, байршилд 10 дугаар сарын 16-ны өдөр дахин зарласан. Үйлчилгээний 5 төрөлд нийт 20 үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос сонгон шалгаруулалтаар 3 төрөлд нийт 9 тусгай зөвшөөрөл олгогдсон.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Сонгон шалгаруулалтаар олгохоор зарласан тусгай зөвшөөрлийн тоо	Үүнээс		Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо
			Олгосон	Татгалзсан	
1	Арилжааны радио-орон нутагт	10 ¹	6 ²	-	16
2	Өргөн нэвтрүүлгийн телевиз-орон нутагт	7 ³	2 ⁴	-	45
3	Арилжааны телевиз-орон нутагт	1 ⁵	-	-	3
4	ОСДҮ (утастай, утасгүй сүлжээгээр) – орон нутагт	1 ⁶	1	-	17
5	ОСДҮ (ОТТ) - Монгол Улс	1 ⁷	-	-	2

Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 4 аймагт, телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 6 аймагт, ОСДҮ-ний тусгай зөвшөөрлийг 1 аймагт тус тус 2 удаагийн сонгон шалгаруулалтыг зарласан боловч сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирээгүй.

¹ Баянхонгор, Булган, Дорноговь, Дундговь, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий аймагт

² Дорноговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий аймагт

³ Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэ аймагт

⁴ Дорноговь, Өвөрхангай аймагт

⁵ Хэнтий аймаг

⁶ Дорноговь аймагт

⁷ Монгол Улсын нутаг дэвсгэрт

Хоёр. Төлбөртэй телевизийн төрөлд тусгай зөвшөөрөл олгох хүсэлт шийдвэрлэсэн байдал

Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн хүсэлтийн тоо	Үүнээс		Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо
		Олгосон	Татгалзсан	
Төлбөртэй телевиз	8 ⁸	8	-	21

Гурав: Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн арга хэмжээний талаар

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрлийн тоо	Үүнээс		Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо
			Сэргээсэн	Хүчингүй болсон	
1	Өргөн нэвтрүүлгийн телевиз-Орон нутаг	3	2 ⁹	1 ¹⁰	45
2	Арилжааны телевиз-УБ хот	5	3 ¹¹	2 ¹²	54
3	Арилжааны радио	7	6 ¹³	1 ¹⁴	59

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байдал

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Сунгалт хийх хүсэлт ирүүлсэн тусгай зөвшөөрлийн тоо	Үүнээс		Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо
			Сунгасан	Татгалзсан	
1	Үндэсний олон нийтийн телевиз	3	3	-	5
2	Өргөн нэвтрүүлгийн телевиз-УБ хот	4	4	-	18
3	Өргөн нэвтрүүлгийн телевиз-Орон нутаг	14	14	-	45

⁸ Маст технологи ХХК, Номадиа нэтворк ХХК, Монвсат ХХК, Скайтел ХХК, Мөүви бокс плас ХХК.

⁹ Ойрад телевиз ХХК, Миний монгол энтертайнмэнт ХХК

¹⁰ Лха сүлдэн тэнгэр ХХК ЗтХ-ийн 6.2.1.2-т заасан үндэслэлээр

¹¹ Эгон ХХК, Буган соёл ХХК, Монгол телевиз ХХК

¹² Эм жи эл медиа групп ХХК, Байсикл медиа ХХК тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон

¹³ Топ дэвшил ХХК, И Зэт ФМ ХХК, Улаанбаатар телевиз ХХК, Шүхэр ТББ, Сайн цагийн залуус ТББ, Рашаантын баясгалант ХХК

¹⁴ Монкаст радио ХХК-ийн тусгай зөвшөөрлийг ӨНТХ-ийн 17.1-д заасан үндэслэлээр

4	Арилжааны телевиз-УБ хот	18	18	-	54
5	Арилжааны телевиз-Орон нутаг	1	1	-	3
6	Арилжааны радио	8	8	-	59
7	Олон суваг дамжуулах үйлчилгээ	4	4	-	30

Тав. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байдал

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Хүчингүй болсон тусгай зөвшөөрлийн тоо	Үндэслэл	Хугацааны эцэст тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо
1	Арилжааны телевиз-УБ хот	2	ЗтХ-ийн 6.2 дугаар зүйлийн 1.2. зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй -2 ¹⁵	54
2	Арилжааны радио	7	Сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгосон боловч тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулаагүй -3 ¹⁶ ЗтХ-ийн 6.2 дугаар зүйлийн 1.2. зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй – 1 ¹⁷ ЗтХ-ийн 6.2 дугаар зүйлийн 1.1 зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан – 2 ¹⁸ ӨНТХ-ийн 17.1 тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан - 1 ¹⁹	59

¹⁵ Эм Жи Эл Медиа групп ХХК, Байсикл медиа ХХК

¹⁶ Давхар дэлгэц ХХК, Өндөр цэнгэл хайрхан ХХК, Ойрад ТВ ХХК

¹⁷ Монкаст радио ХХК

¹⁸ Дархан комфорт цогцолбор ХХК, Номин макс ХХК

¹⁹ Лха ХХК

3	Өргөн нэвтрүүлгийн телевиз-Орон нутаг	4	ЗтХ-ийн 6.2 дугаар зүйлийн 1.1 зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан - 3 ²⁰ ЗтХ-ийн 6.2 дугаар зүйлийн 1.2. зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй – 1 ²¹	45
4	Олон суваг дамжуулах үйлчилгээ	1	ЗтХ-ийн 6.2 дугаар зүйлийн 1.1 зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан - 1 ²²	30

Зургаа. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Нэмэлт, өөрчлөлт оруулсан тусгай зөвшөөрлийн тоо, нэр	Үүнээс		
			Тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн, хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн	Үйлчилгээ эрхлэх хүрээ өөрчилсөн	Үйлчилгээний нэр өөрчилсөн
1	Арилжааны телевиз-УБ хот	4	1 ²³	1 ²⁴	2 ²⁵
2	Өргөн нэвтрүүлгийн телевиз-Орон нутаг	2	2 ²⁶	-	45
3	Олон суваг дамжуулах үйлчилгээ	1	-	1 ²⁷	-

²⁰ Хувь хүний хөгжлийн баруун бүсийн институт ТББ-ын Гэгээ ТВ, Жавхлант ширээ ХХК-ийн Шинэ завхан ТВ, Иргэн Мөнхбаярын Од ТВ.

²¹ Лха сүлдэн тэнгэр ХХК-ийн Түмний ТВ

²² Халиун кабель ХХК

²³ Трейд телевиз ХХК нь нэрээ Хөгжил телевиз ХХК болгон өөрчилсөн

²⁴ Монвсат нэтворкс ХХК-ийн үйлчилгээ эрхлэх хүрээг Монгол Улс болгосон

²⁵ Монгол телевиз ХХК-ийн VolumePlus телевиз нэрээ MongolTV+1, Форчун глобал ХХК-ийн Глобал телевиз нэрээ Айт Глобал телевиз болгосон

²⁶ Мичид ньус ХХК-аас Үлэмж медиа ХХК руу, Аа жи би ви виз ХХК-аас Нью Ар Жи Би ТВ ХХК руу шилжүүлсэн

²⁷ Монголын цахилгаан холбоо ХК-ийн үйлчилгээний хамрах хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэрт болгосон

III. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙЛГАХ ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

ӨНТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасны дагуу өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгахаар зохицуулсан. ХХЗХ-оос уг хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.5, 30 дугаар зүйлийн 30.1.2-т заасан бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж, тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс (радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч, радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч) эзэмшлийн мэдээллийг хүлээн авч, жил бүрийн 12 дугаар сарын 31-ний байдлаар хүлээн авч, нэгтгэн 1-р улиралд багтаан олон нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна. ХХЗХ-ноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн 2023 оны мэдээлэлтэй тус хорооны цахим хуудас <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=304>-с дэлгэрэнгүй танилцах боломжтой.

IV. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ, ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Нэг. Монгол Улсын хүн ам, өрхийн тоо, нягтралын байдал

Үндэсний Статистикийн хорооны статистикийн тайлангаар 2023 оны байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3,396,788, өрхийн тоо 983,485 байгаагаас Улаанбаатар хотын хүн ам 1,640,781, өрх 465,059, орон нутгийн хүн ам 1,756,007, өрхийн тоо 518,426 байна. Хүн амын тоо 2022 онтой харьцуулахад улсын хэмжээнд 0.8%-иар, Улаанбаатар хотын хувьд 2.8%-иар өссөн бол орон нутагт 0.9%-иар буурсан байна. Орон нутгийн хувьд Говьсүмбэр, Өмнөговь, Сүхбаатар аймгуудын хүн ам, өрхийн тоо өссөн бол бусад аймгуудын хувьд буурсан үзүүлэлт үзүүлжээ.

Хүн амын нягтралын түвшин 2023 онд Монгол Улсын хэмжээнд 2.2, баруун бүсийн хэмжээнд 1, хангайн бүс 1.6, төвийн бүс 1.1, зүүн бүс 0.8 байгаа нь өмнөх оныхтой ижил үзүүлэлттэй байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 369.1 болж нэмэгдсэн нь 2022 онтой харьцуулахад 9.1-ээр нэмэгдсэн үзүүлэлтийг үзүүлжээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг Үндэсний статистикийн хорооны <https://www.1212.mn/mn> сайтаас үзэх боломжтой.

Хоёр. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

ХХЗХ-ноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 240 байна.

№	Үйлчилгээний төрөл	Үйлчилгээ эрхлэгчийн тоо
1	Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ	1
2	Олон нийтийн телевиз, радио	Телевиз – 5 Радио - 4

3	Олон суваг дамжуулах үйлчилгээ	Улаанбаатар хот – 13 Орон нутагт - 17
4	Арилжааны телевизийн үйлчилгээ	Улаанбаатар хот –54 Орон нутагт – 3
5	Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ	Улаанбаатар хот –18 Орон нутагт – 45
6	Радиоогийн үйлчилгээ эрхлэгч	Улаанбаатар хот –31 Орон нутагт - 28
7	Төлбөртэй телевиз	21

Гурав. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдал

Телевизийн зах зээлийн хэмжээ:

Телевизийн зах зээлийн хэмжээ зах зээлийн хэмжээ 2022 оны статистикийн тайлан мэдээгээр 77.2 тэрбум төгрөг байсан бол 2023 оны мэдээгээр 95.3 тэрбум төгрөг болж 23%-иар өсжээ.

Тэрбум төгрөгөөр

Зах зээлийн хэмжээ	2021 он	2022 он	2023 он
Өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээл	44.6	55.3	61.4
Арилжааны телевизийн зах зээл	25.1	21.9	33.9
Телевизийн нийт зах зээл	69.7	77.2	95.3

Үүнээс өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээл 61.4 тэрбум төгрөг буюу 64.4%, арилжааны телевизийн зах зээл 33.9 тэрбум төгрөг буюу 35.6%-ийг эзэлж байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн орлогын 2020 онд 93.9%, 2021 онд 95.3%, 2022 онд 97%, 2023 онд 96.6%-ийг Улаанбаатар хотын бөгөөд Монгол Улсад хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, үлдсэн хувийг орон нутгийн 45 телевиз бүрдүүлж байна.

Арилжааны телевизийн зах зээлийн орлогын 2020 онд 97.6%, 2021 онд 99.7%, 2022 онд 99.6%, 2023 онд 99.9%-ийг Улаанбаатар хотын (МУ-д хамрах хүрээтэй 39) арилжааны 54 телевиз, үлдсэн хувийг орон нутгийн 3 арилжааны телевиз бүрдүүлж байна.

2023 оны дүнгээр Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн 45%-ийг топ 3 телевиз эзэлж байгаа бөгөөд энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 4%-иар өссөн, зах зээлийн 3 хүртэл хувийг эзэлдэг 8 телевизийн зах зээлд эзлэх хувь нийлбэр дүнгээр 18%-тай, бусад 7 телевиз 5-7%-ийг тогтвортой бүрдүүлж байна. Зах зээл дэх төвлөрлийн түвшин

(Concentration ratio²⁸, төвлөрлийн түвшин, цаашид CR гэх) 2020 онд CR 64%, өрсөлдөөний түвшин (Herfindahl–Hirschman index²⁹, өрсөлдөөний түвшин, цаашид ННН гэх) 2020 онд ННН 1116-тай буюу төвлөрлийн түвшин дунд, 2021 онд CR 56%, ННН 1093, 2022 онд CR 43%, ННН 949, 2023 онд CR 59%, ННН-815 байгаа нь төвлөрлийн түвшин бага, зах зээлд хангалттай тооны өрсөлдөгчтэй бөгөөд төвлөрөл байхгүй гэсэн үзүүлэлттэй байна.

УБ хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн төвлөрөл	2020 он	2021 он	2022 он	2023 он
Төвлөрлийн хувь (CR)	64%	56%	43%	59%
Херфиндал - Хиршман Индекс (ННН)	1116	1093	949	815

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн зардал 2020 онд 30,9 тэрбум төгрөг, 2021 онд 40,1 тэрбум төгрөг, 2022 онд 43,9 тэрбум төгрөг, 2023 онд 54,6 тэрбум төгрөг тус тус байна. Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 2023 онд нийт 3,9 тэрбум төгрөг байгаа ба үүний 3,6 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүд, 0,3 тэрбум төгрөгийг орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизүүд бүрдүүлсэн байна.

Арилжааны телевизийн зах зээлд топ 4 телевизийн эзлэх хувь 2022 оны дүнгээр арилжааны телевизийн зах зээлийн 76%-ийг эзэлж байсан бол 2023 онд 87% хүрч өссөн байна. Статистик тайлан ирүүлсэн арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2020 онд 28, 2021 онд 36, 2022 онд 29, 2023 онд 43 байна. Зах зээл дэх төвлөрлийн түвшин 2020 онд CR 84%, ННН 1864 -тай төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал, 2021 онд CR 76%, ННН 1498-тай төвлөрлийн түвшин дундаж, дунд зэргийн төвлөрөлтэй, 2022 онд CR 83%, ННН 1929-тай төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал, 2023 онд CR 87%, ННН 2999-тай төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал гэсэн үзүүлэлттэй байна.

УБ хотын арилжааны телевизийн зах зээлийн төвлөрөл	2020 он	2021 он	2022 он	2023 он
Төвлөрлийн хувь (CR)	84.1%	76%	83.3%	87%
Херфиндал- Хиршман Индекс (ННН)	1864	1498	1929	2999

Улаанбаатар хотын арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн зардал 2020 онд 23,9 тэрбум төгрөг, 2021 онд 25,1 тэрбум төгрөг, 2022 онд 19,5 тэрбум төгрөг, 2023 онд 38

²⁸ Төвлөрлийн харьцааны индекс нь 1-ээс 100 хувийн утга авах бөгөөд үүгээр тухайн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний нөхцөл байдлыг тодорхойлно. Өрсөлдөөний зохицуулалтын практикт ихэнхдээ зах зээл дэх 3, 4, эсвэл 5 томоохон үйлчилгээ эрхлэгчийн төвлөрлийг тодорхойлж үздэг ба хэрэв индексийн утга 80-100 бол төвлөрлийн түвшин өндөр, 50-80 бол төвлөрлийн түвшин дундаж, 0-50 бол төвлөрлийн түвшин бага гэж үзнэ.

²⁹ Энэхүү индекс нэгтэй тэнцүү байх нөхцөлд тухайн зах зээлд зөвхөн нэг үйлчилгээ эрхлэгч (монопол) байна. Хэрэв индексийн утга ХХН<ХХН1800 бол тухайн зах зээлд төвлөрлийн түвшин өндөр буюу өрсөлдөөн хязгаарлагдмал гэж үзнэ.

тэрбум төгрөг тус тус байна. Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 2022 онд нийт 4,6 тэрбум төгрөг, 2023 онд 1 тэрбум төгрөг байна.

Олон сувгийн зах зээлийн хэмжээ:

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн хэрэглэгчийн тоон судалгааны хувьд 2021 онд нийт 808,463 идэвхтэй хэрэглэгч бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 456,691, орон нутагт 351,772 байсан бол 2022 онд нийт 760,028 идэвхтэй хэрэглэгч бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 424,925, орон нутагт 335,103 хэрэглэгч, 2023 онд 761,800 идэвхтэй хэрэглэгч бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 447,738, орон нутагт 314,062 хэрэглэгч байна. Хэрэглэгчийн тооны судалгааг телевизийн олон суваг дамжуулж байгаа технологийн төрөл, үйлчилгээ эрхлэгч, үйлчилгээ эрхлэх хүрээгээр гаргасан.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн статистик тайлан мэдээний ирцийг авч үзэхэд 2021 онд 31, 2022 онд 30, 2023 онд 26 үйлчилгээ эрхлэгч статистик тайлан мэдээ ирүүлсэн байна. Олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлийн хэмжээ 2021 оны статистик тайлан мэдээгээр 281,1 тэрбум төгрөг, 2022 онд 323,8 тэрбум төгрөг, 2023 онд 382,3 тэрбум төгрөг болж өссөн. Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого 2023 онд өмнөх онтой харьцуулахад 18%-иар өссөн бөгөөд интернэт протоколд суурилсан үйлчилгээний орлого 20%, хиймэл дагуулын үйлчилгээний орлого 7% тус тус өссөн бол утастай, утасгүй сүлжээний орлого ердөө 0.2% өссөн байна.

Зардал 2023 онд 251,2 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 15%-иар өссөн. Хөрөнгө оруулалт 2021 онд 36,1 тэрбум төгрөг, 2022 онд 25,9 тэрбум төгрөг, 2023 онд 17,3 тэрбум төгрөг байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого 2021 онд 40 тэрбум төгрөг, 2022 онд 48,8 тэрбум төгрөг, 2023 онд 39,2 тэрбум төгрөг байна. Нэгж хэрэглэгчээс олох сарын орлого дунджаар 2021 онд 28,978 төгрөг, 2022 онд 28,155 төгрөг байсан бол 2023 онд 30,747 төгрөг болж өссөн байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний Улаанбаатар хотын зах зээлийн хувьд 2021 онд 456,691 хэрэглэгч, 2022 онд 424,925 хэрэглэгч, 2023 онд 447,738 хэрэглэгч идэвхтэй байгаа бөгөөд үүний 93% нь төвийн 6 дүүрэгт, үлдсэн 7% нь алслагдсан 3 дүүрэгт харьяалагдаж байна. Зах зээлийн нэвтрэлт нийслэлийн хэмжээнд дунджаар 103%-тай байгаа бол орон нутагт дунджаар 60%-тай байна.

Зах зээл дэх төвлөрлийн түвшин 2021 онд CR 86%, ННІ 2700, 2022 онд CR 94%, ННІ 3644, 2023 онд CR 94.2%, ННІ 4292 байгаа нь төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал байдалтай байна.

Өрсөлдөөний нөхцөл байдал	2021 он	2022 он	2023 он
Төвлөрлийн хувь (CR)	86%	94%	94.2%
Херфиндал-Хиршман Индекс (ННІ)	2700	3644	4292

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 2023 онд нийт 19,2 тэрбум төгрөг байгаа ба үүний 17,3 тэрбум төгрөгийг интернэт протоколд суурилсан 2 үйлчилгээ эрхлэгч, 1 тэрбум төгрөгийг хиймэл дагуулын үйлчилгээ эрхлэгч бүрдүүлсэн байна.

Радиоогийн зах зээлийн хэмжээ:

Радиоогийн зах зээлийн хэмжээ 2020 онд 1,5 тэрбум төгрөг, 2021 онд 2,2 тэрбум төгрөг, 2022 онд 3,3 тэрбум төгрөг, 2023 онд 3,9 тэрбум төгрөг болж өссөн буюу сүүлийн 3 жилийн судалгаагаар өссөн үзүүлэлттэй байна. Нийт орлогын 91%-ийг Улаанбаатар хотын радиоогийн үйлчилгээ эрхлэгчид бүрдүүлж байгаагийн 77%-ийг нэг этгээд дангаараа бүрдүүлж байна. Радиоогийн үйлчилгээ эрхлэгчдийн зардал 2020 онд 1,9 тэрбум төгрөг, 2021 онд 1,6 тэрбум төгрөг, 2022 онд 1,7 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 2,3 тэрбум төгрөг болсон байна.

Зах зээл дэх төвлөрлийн түвшин 2021 онд CR 90%, ННН 4719-тэй, 2022 онд CR 91%, ННН 4674-тэй, 2023 онд CR 93%, ННН 6039-тэй төвлөрлийн түвшин өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал байдалтай байна. Салбарт оруулсан хөрөнгө оруулалт 1,1 тэрбум төгрөг байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргадаг хагас жил болон жилийн эцсийн салбарын үндсэн үзүүлэлт, статистик дата мэдээллийн дэлгэрэнгүйг <https://www.crc.gov.mn/list/zah-zeel-rs-ldn/mn?show=45> хуудаснаас он тус бүрээр дэлгэрүүлэн үзэх боломжтой ба салбарын 2023 оны жилийн эцсийн үндсэн үзүүлэлт, дата мэдээллийг <https://statistic.crc.gov.mn/#/infograph/4162> -с татан авч, танилцана уу.

Дөрөв. Эрэлт, хэрэгцээ

ХХЗХ нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоохоор хуульчилсан бөгөөд тухайн үйлчилгээг эрхлэх эрэлт, хэрэгцээ байгаа эсийг тодорхойлох зорилгоор судалгааны асуулга буюу мэдээлэл ирүүлэх маягт гаргаж өөрийн цахим хуудаст <https://shorturl.at/cqjLV> байршуулж сонирхогч этгээдүүдээс мэдээлэл хүлээн авч ажиллаж байна.

Энэ дагуу 2020 онд ирүүлсэн судалгааг үндэслэн 2020 оны 91 тоот тогтоолоор, 2021 онд ирүүлсэн судалгааг үндэслэн 2021 оны 71 тоот тогтоолоор тус тус тусгай зөвшөөрлийн тоог баталж байсан бөгөөд 2021 оны тоо тогтоох судалгаа, дүгнэлтээр гарсан саналын дагуу нэр бүхий аймагт үйлчилгээ эрхлэх судалгааг дахин авч үзэж, мөн 2022, 2023 онд тус хороонд ирүүлсэн сонирхогч этгээдийн судалгаа, мэдээллийг нэгтгэж 2023 оны 35 тоот тогтоолоор тусгай зөвшөөрөл олгох тоог тогтоосон.

Сонгон шалгаруулалтаар 2021-2023 онуудад нийт олон суваг дамжуулах үйлчилгээний 3 тусгай зөвшөөрөл олгох тоо тогтоосноос сонгон шалгаруулалтаар 2 тусгай зөвшөөрөл олгогдсон, өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөл олгох нийт 18 тоо тогтоож сонгон шалгаруулалт зарласнаас 8 тусгай зөвшөөрөл олгогдсон, арилжааны телевизийн 1 тусгай зөвшөөрлийн тоо тогтоож сонгон шалгаруулалт зарласан боловч хүсэлт ирээгүй, орон нутагт радиоогийн 25 тусгай зөвшөөрлийн тоо тогтоосноос сонгон шалгаруулалтаар 8 тусгай зөвшөөрөл тус тус олгогдоод байна. Дэлгэрэнгүйг доорх хүснэгтэд үзүүлээ.

Тусгай зөвшөөрлийн төрөл	МУ-ын нутаг дэвсгэрт	Аймагт	Нийт зарласан/ олгосон
Олон суваг дамжуулах үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • 2021 онд 1 квот тогтоосноос олгосон: 1 • 2023 онд 1 квот тогтоосноос олгосон: 0 	<ul style="list-style-type: none"> • 2023 онд 1 аймагт 1 квот тогтоосноос олгосон: 1 (1 аймагт) 	3/2
Өргөн нэвтрүүлгийн телевиз үйлчилгээ	-	<ul style="list-style-type: none"> • 2021 онд 8 аймагт 11 квот тогтоосноос олгосон: 6 (6 аймагт) • 2023 онд 7 аймагт 7 квот тогтоосноос олгосон: 2 (2 аймагт) 	18/8
Арилжааны телевизийн үйлчилгээ	-	<ul style="list-style-type: none"> • 2023 онд 1 аймагт 1 квот тогтоосноос олгосон: 0 	1/0
Арилжааны радиогийн үйлчилгээ	-	<ul style="list-style-type: none"> • 2021 онд 12 аймагт 12 квот тогтоосноос олгосон: 2 (т.з гэрээ байгуулаагүй тул хүчингүй болгосон) • 2022 онд 3 аймагт 3 квот тогтоосноос олгосон: 2 (2 аймагт) • 2023 онд 10 аймагт 10 квот тогтоосноос олгосон: 6 (6 аймагт) 	25/8

2024 онд Дорнод аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх 1 санал ирсэн бөгөөд бусад үйлчилгээний төрөл, ангилалд санал ирээгүй байна.

V. ХОРООНООС 2024 ОНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОО ТОГТООХ ЭСЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ХАРГАЛЗАН ҮЗСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ШИЙДВЭР

Нэг. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлтүүд

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрлийг ӨНТХ-ийн 6 дугаар зүйл, тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг ЗТХ-ийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9 дэх заалтаар тус тус тогтоосон.

ӨНТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлнэ.” гэж; 7 дугаар зүйлийн 7.4.2-т “өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэх;” гэж; 7.4.5-д “энэ хуулийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах;” гэж; 30 дугаар зүйлийн 30.1.9-д “өргөн нэвтрүүлгийн зах зээлийн

багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоох;" гэж; 30.1.10-т "хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;" гэж тус тус тодорхойлсны дагуу ХХЗХ-ноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой харилцааг хуульчилсан.

ЗТХ-д батлагдаж 2023 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой ӨНТХ-д 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох журмыг тусгаж, үүнтэй холбоотой ХХЗХ-ны 2020 оны 64 дүгээр тогтоолоор баталсан "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам"-ыг тус хорооны 2023 оны 2 тоот тогтоолоор хүчингүй болгосон. ӨНТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6-д "Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9-д заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгоно." гэж заасны дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх дараах төрлийн тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулах зарчмыг баримтлан олгодог. Үүнд:

- Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх;
- Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх;
- Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх;
- Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн дээрх төрөлд нээлттэй сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох тоо тогтооход ӨНТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1.9-ийн дагуу өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэхээр заасан бөгөөд судалгааг дараах холбогдох чиглэлд хийж, уг судалгаанд үндэслэн сонгон шалгаруулалт зарлах шаардлагатай эсэхэд дүгнэлт гаргасан болно.

1. Монгол Улс, Улаанбаатар хот, орон нутгийн хүн ам, өрхийн тоо, нягтралын судалгаа;
2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо;
3. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгаа;
4. Эрэлт, хэрэгцээ.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд холбогдох дээрх судалгаа, мэдээллээс гадна дараах шалгуурыг харгалзан үзсэн. Үүнд:

1. Радио давтамжийн тусгай зөвшөөрөл шаардлагатай бол радио давтамжийн төлөвлөлт, нөөц;
2. ӨНТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасан зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээний сувгийн багтаамж, нөхцөл байдлыг тодорхойлох.

Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээний ашиглалтыг төр хариуцах бөгөөд уг сүлжээнд олон нийтийн радио, телевиз болон өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг үнэ төлбөргүйгээр холбох, дамжуулах хуулийн зохицуулалт хэрэгждэг ба нээлттэй сонгон шалгаруулалтаар өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тоо тогтоох нөхцөлд газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн сүлжээ, сувгийн багтаамж, техникийн нөхцөл байдлыг харгалзан авч үзэх шаардлагатай байдаг. Иймээс Радио, телевизийн газрын сүлжээ УТҮГ-аас техникийн нөхцөлийг авч үзсэн.

Хоёр: Тус Хорооноос 2024 онд сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх тухай

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газраас ӨНТХ-ийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн зүйлийн 7.4.1, 7.4.2, 7.4.5 дахь заалтууд, 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹.1.11, 11.4 дэх заалтыг тус тус үндэслэн Өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаар хийсэн судалгаа, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх талаар судалгаа, дүгнэлтийг хийж 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Даргын зөвлөлийн хурал, 04 дүгээр сарын 18-ны өдрийн Хорооны хуралдаанд тус тус танилцуулсан.

Хорооны хуралдаанаар энэ удаагийн судалгаа, дүгнэлтээр өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тоо тогтоох хэрэгцээ, шаардлага үүсээгүй байна гэж үзлээ. Гэвч цаашид радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч байхгүй аймагт үйлчилгээ эрхлэх эрэлт, хэрэгцээ үүссэн эсхүл тодорхой бүс нутагт үйлчилгээ эрхлэх, радио давтамж ашиглахаар сонирхогч этгээдүүд хүсэлт ирүүлсэн зэрэг шаардлагатай тохиолдолд тухайн үйлчилгээ эрхлэх хүрээнд 2024 онд сонгон шалгаруулалтаар олгох радио, телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх асуудлыг холбогдох мэдээлэл, судалгааны хамт Хорооны хуралдаанд тухайн үед нь танилцуулж шийдвэрлүүлэх удирдамж, чиглэлийг өгсөн болно.

Иймд 2024 онд аймагт үйлчилгээ эрхлэх эрэлт, хэрэгцээ үүссэн эсхүл тодорхой бүс нутагт үйлчилгээ эрхлэх, радио давтамж ашиглахаар сонирхогч этгээдүүд хүсэлт ирүүлэх зэрэг тохиолдолд холбогдох судалгааг дахин хийж шийдвэрлэхээр боллоо.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО